



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 431

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 63 дугаар зүйлийн 63.1.5, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 45.5, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголиа велт менежмент ҮЦК” ХХК-ийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаагүй тохиолдолд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг “Монголиа велт менежмент ҮЦК” ХХК-ийн /Х.Ганхөлөг/ удирдлага, эрх бүхий албан тушаалтанд анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын албанд ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН